



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/557

Есөнбулаг

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журмын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн хошой соёрхолт, эрдэмтэн зохиолч Чадраабалын Лодойдамбын нэрэмжит Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн түүхт 60 жилийн ойг 2024 оны 09 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд, "Хантайшир-Эрдэм" цогцолбор сургуулийн 30 жилийн ойг 2024 оны 09 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2.Ойг зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн тусалж, хамтарч ажиллахыг Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т, бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан, чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн захирал (Э.Тэрбиш), "Хантайшир-Эрдэм" цогцолбор сургуулийн захирал (Т.Алдарсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ